

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

*Хувьцаат компани болон төрийн өмчид
компанид зориулсан гарын авлага*





НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

*Хувьцаат компани болон төрийн өмчит
компанид зориулсан гарын авлага*

Улаанбаатар хот
2018 он

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

*Хувьцаат компани болон төрийн өмчит
компанид зориулсан гарын авлага*

© Нээлттэй Нийгэм Форум, 2018

Гарын авлагыг бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, нийтлэх, микрофильм хийх, электрон системд оруулах, бусад ямарваа хэлбэрээр олшруулахыг хүсвэл ННФ-д хандаж зохих зөвшөөрөл авна уу.

Гарын авлага боловсруулсан: Д.Байлхүү, Судлаач

Редактор: Т.Жамбаажамц, Хуульч

Эх бэлтгэл: Д.Баттулга

ISBN: 978-99978-803-2-1



976-11-313207



osf@forum.mn



976-11-324857



Нээлттэй Нийгэм Форум

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьян гүний
гудамж-5/1, Улаанбаатар-14240, Монгол Улс

ӨМНӨХ ҮГ

Нийтийн өмч болох байгалийн баялагт тулгуурлан бизнес эрхэлж буй төрийн өмчит компаниудын засаглалыг бэхжүүлэх нь зөвхөн тухайн компанийн төдийгүй нийт улс орны тогтвортой хөгжил, ард иргэдийн нийтлэг эрх ашигт нийцсэн чухал асуудал юм. 1991 онд Аж ахуйн нэгжийн тухай хуулийг батлан гаргаснаас хойш бизнесийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинэчилж, сайжруулсаар ирсэн хэдий ч холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт хангалтгүйн улмаас компанийн засаглалын түвшин шаардлагатай хэмжээнд хүртэл сайжирч чадахгүй байна. 2014 онд Нээлттэй Нийгэм Форумгаас хийсэн “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын засаглалд үнэлгээ” судалгааны дүн ч үүнийг харуулсан билээ.

Нээлттэй Нийгэм Форумгаас төрийн өмчит уул уурхайн томоохон компаниудыг сонгон авч засаглалын түвшнийг нь харьцуулан тодорхойлсон уг судалгаагаар хангалтгүй үнэлгээ авсан компанийн засаглалын гол элементүүдийг сайжруулахад дэмжлэг болох үүднээс цуврал гарын авлага бэлтгэн гаргаж байна. Үүний эхнийх нь болох “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зохион байгуулалт” сэдэвт гарын авлагыг Танд хүргэж байна.

Хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх, компанийн удирдлагад оролцох гол хэлбэр нь хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ) боловч хурал зохион байгуулахтай холбоотой цогц ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор зохион байгуулдаггүйгээс хувьцаа эзэмшигчид хуралдаа оролцож, санал өгөх үндсэн эрхээ хэрэгжүүлж чадахгүйд хүрэх явдал цөөнгүй гарч байна.

Иймээс энэхүү гарын авлагад ХЭХ хуралдуулах шийдвэр гаргаж, тов тогтоохоос эхлээд хурлын бэлтгэл хангах, хурлын шийдвэрийг хэрэгжүүлж хувьцаа эзэмшигчдэд эргэж мэдээлэх хүртэлх бүх үе шатанд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг чанд сахин мөрдөх ажиллагааны зааврыг хялбаршуулан багтаав. Уг зааврыг мөрдөн ажиллах нь компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хангахад, цаашлаад компанийн засаглал, үйл ажиллагаа зохистой, тогтвортой байхад чухал ач холбогдолтой юм.

Түүнчлэн, компанийн төлөөлөн удирдах зөвлөл болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарт зориулсан, бүх төрлийн өмчийн компаниуд өөрийн онцлогт тохируулан хэрэглэх боломжтой энэхүү гарын авлага нь компанийн үндсэн хөрөнгө оруулагч болох хувьцаа эзэмшигчдийн эрхийг хангах замаар компанийн засаглалыг сайжруулж бэхжүүлэхэд зохих хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

Энэхүү гарын авлагыг бэлтгэн гаргахад үнэтэй хувь нэмэр оруулсан судлаач Д.Байлхүү, хянан тохиолдуулсан хуульч Т.Жамбаажамц нарт талархал илэрхийлье.

Тус гарын авлагатай холбоотой саналаа ННФ-ын osf@forum.mn хаягаар ирүүлнэ үү.

Гүйцэтгэх Захирал П.Эрдэнэжаргал

АГУУЛГА

1.	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ, ТҮҮНИЙ ТӨРЛҮҮД.....	6
1.1	Ээлжит хурал	7
1.2	Ээлжит бус хурал.....	10
1.3	Хойшлогдсон хурал	12
1.4	Хувьцаа эзэмшигчид эчнээ санал хураалтаар шийдвэр гаргах.....	14
1.5	Нэг хувьцаа эзэмшигчтэй компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх онцлог.....	17
2.	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН БҮРЭН ЭРХ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ.....	19
3.	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН БЭЛТГЭЛ ХАНГАХ	21
3.1	Хурал хуралдуулах санал гаргах	21
3.2	Хурлын хэлэлцэх асуудал.....	24
3.3	Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох	26
3.4	Хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах, хурлын тов тогтоох	27
3.5	Хурлын зар хүргэх	30
3.6	Саналын хуудас, түүний бүтэц	33
3.7	Хурлын дарга	35
3.8	Тооллогын комисс, түүний эрх үүрэг, үйл ажиллагаа	36
4.	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛДААН	38
4.1	Хуралд оролцох хэлбэр.....	38
4.2	Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийг бүртгэх	39
4.3	Хурлын ирцийг тодорхойлох	40
4.4	Асуудал хэлэлцэх үйл явц ба саналын хуудсаар ирүүлсэн саналыг тоолох ажиллагаа	40
4.5	Шийдвэр гаргах ажиллагаа	41
4.6	Хурлын тэмдэглэл, түүнийг хөтлөх	42
5.	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРААХ АЖИЛЛАГАА.....	45
5.1	Хувьцаа эзэмшигчдийн хурал болон түүний шийдвэртэй холбогдон гарч болох гомдол санал	45
5.2	Хувьцаа эзэмшигчдийн хурлын бичиг баримтыг цэгцлэх, хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх.....	46
	ХАВСРАЛТУУД	47
	АШИГЛАСАН МАТЕРИАЛ	57
	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛТАЙ ХОЛБООТОЙ ӨРГӨН ХЭРЭГЛЭГДДЭГ ЗАРИМ ҮГИЙН МОНГОЛ-ОРОС-АНГЛИ ТОЛЬ.....	58

1. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ, ТҮҮНИЙ ТӨРЛҮҮД

Хувьцаа эзэмшигчид нь компанийн гол хөрөнгө оруулагч этгээд хэдий ч тухайн компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тэр бүр оролцоод байдаггүй. Ялангуяа компанийн гол өмчлөгч буюу томоохон хувьцаа эзэмшигч болон компанийн удирдлага хоёрыг ялгаа, заагтай байлгах нь компанийн сайн засаглалын нийтлэг шаардлага юм. Учир нь хувьцаа эзэмшигч бүр компанийг удирдах мэргэжил, туршлага эзэмших албагүйгээс гадна өөр өөр хандлага, үзэл бодол, зорилготой мэргэжлийн бус олон хүн компанийн удирдлагыг зэрэгцэн хэрэгжүүлэх боломжгүй. Иймд дэлхий дахинд “хувьцаа эзэмшигчдийн хурал” гэсэн удирдлагын бүтцийг бий болгож, түүгээр дамжуулан компанийн өмчлөгчийн эрх, үүргийг гүйцэтгэх бололцоог нээжээ. Үүнийг ч Монголын Улсын Компанийн тухай хуульд “Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна” гэж заасан.¹ Эндээс үзэхэд хувьцаа эзэмшигчдийн хурал /цаашид “ХЭХ” гэх/ нь нэг талаас, хувьцаа эзэмшигч санал өгөх эрхээрээ дамжуулан компанийг удирдах эрхээ хэрэгжүүлж буй хэлбэр бол нөгөө талаас, компанийн удирдлагын дээд эрх мэдлийг хэрэгжүүлэгч, үндсэн чухал шийдвэрийг гаргах чиг үүрэг бүхий удирдлагын бүтэц болох нь харагдаж байна.

ХЭХ-ын гол онцлог нь хэлэлцэх асуудал болон гарах шийдвэрийн төсөл хурлаас өмнө тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн хурлаар батлагдаж, саналын хуудсанд тусгагдан хувьцаа эзэмшигчдэд хүргэгдэж, тэд саналаа хурлын өмнө ирүүлэх ба уг саналд үндэслэн хурлын шийдвэр гардагт оршино. Хурлын шийдвэрийг дээрх журмаар гаргах хэд хэдэн шалтгаан бий. Тухайлбал, хувьцаа эзэмшигчид нь компанийн ХЭХ товлөгдсөн газарт

¹ Компанийн тухай хууль 59 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

хүрэлцэн ирэх бололцоогүй хол байх, гадаад улс оронд ажиллаж, амьдарч байх зэрэг олон шалтгааны улмаас хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдол гардаг. Мөн өөр нэг шалтгаан нь ХЭХ-ын шийдвэр хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид гар өргөх замаар бус тэдний эзэмшиж буй саналын эрхтэй хувьцааны тоонд үндэслэж гардаг. Үүнтэй уялдан хувьцаа эзэмшигчид хуралд өөрийн биеэр оролцохоос илүү саналын хуудаст өөрийн саналыг тусган ирүүлэх замаар хуралд оролцох нь элбэг байдаг.

ХЭХ нь ээлжит ба ээлжит бус хурал гэсэн 2 үндсэн хэлбэртэй байдгаас гадна хурлын үйл ажиллагааг хэрэгжүүлэх хэлбэрээс хамаарч эчнээ хурал, хойшлогдсон хурал гэсэн төрөлтэй. Нэг хувьцаа эзэмшигчтэй компанийн хувьд ХЭХ гэсэн удирдлагын бүтэц байдаггүй. Харин түүний бүрэн эрхийг хэрэгжүүлэх гэсэн ойлголт гарч ирдэг. Энэ талаар энэхүү гарын авлагын 1.5-д дэлгэрэнгүй авч үзсэн болно. Хурлын эдгээр төрөл, хэлбэрийн онцлог, хэрэгжүүлэх арга ажиллагааны талаар тус бүрд нь авч үзье.


1.1. ЭЭЛЖИТ ХУРАЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал гэж Компанийн тухай хуулийн 59.4-т заасны дагуу болох хурлыг хэлэх бөгөөд энэ хурал нь хувьцаа эзэмшигчид компанийнхаа тухайн жилийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэн тодорхой шийдвэр, дүгнэлт гаргадгаараа онцлог юм. Дэлхийн олон оронд ээлжит хурал болох хугацааг хуулиар тогтоож өгсөн байдаг. Жишээ нь, Оросын Холбооны Улсад компани нь өөрийн санхүүгийн жил дууссанаас хойш 2-6 сарын хугацаанд багтаан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа заавал зарлан хуралдуулахыг хуулиар шаарддаг. Манай орны хувьд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулахаар тогтоожээ.² Энэ хугацаанд ээлжит хурлаа зарлан хуралдуулаагүй бол тухайн компанийн ТУЗ-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад бүрэн эрх дуусгавар болно гэж Компанийн тухай хуульд заасан байна.³

² Компанийн тухай хууль 59 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг

³ Компанийн тухай хууль 59 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Схем 1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хийгдэх ажлын дараалал болон цаг хугацаа

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах үед хуралтай холбоотой мэдээллээс гадна компанийн зүгээс хувьцаа эзэмшигчдэд заавал хүргэх мэдээллийг Компанийн тухай хуулиар тогтоож⁴ өгсөн байдаг (Зураг 1-д).

⁴ Компанийн тухай хууль 65 дугаар зүйлийн 6 дахь хэсэг



Зураг 1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үед хувьцаа эзэмшигчид хүргэх мэдээлэл

 Санамж

Хувьцаа эзэмшигчдэд хамгийн багадаа жилд нэг удаа компанийн талаар мэдээлэл авч, хэрэв хүсвэл хуралд биечлэн оролцож санал өгөх бололцоо олгох үүднээс хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалт хийх замаар орлуулахыг хуулиар хориглодог⁵. Иймээс ээлжит хуралд хувьцаа эзэмшигч зөвхөн өөрийн биеэр, эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцох боломжтойгоос гадна саналын хуудсаар санал өгөх замаар оролцох боломжтой.


Хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд оролцох бэлтгэлээ хангах, шаардлагатай тохиолдолд хэлэлцэх асуудалд санал оруулах, ТУЗ-ийн гишүүнд өөрийгөө болон бусдын нэрийг дэвшүүлэх зэрэг бололцоог хангах үүднээс хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын товыг урьдчилан тогтоосон байхыг зөвшөөрдөг. Зарим компани энэ хугацааг дүрэмдээ тодорхой зааж өгсөн байдаг. Энэхүү санамжийг үндэслэн компаниуд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын товыг жилийн аль нэг тодорхой сар, өдрөөр тогтоож өгөх нь хувьцаа эзэмшигч бүр хуралд оролцох бэлтгэлээ хангах, шаардлагатай үед тодорхой асуудлаар өгөх саналаа тогтоосон хугацаанд нь гаргах бололцоог олгох юм.

1.2. ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ

Компанийн үйл ажиллагааны жилийн тайланг хэлэлцэн дүгнэх ээлжит хурлаас гадна шаардлагатай тохиолдолд ХЭХ-ыг хэдийд ч зарлан хуралдуулж болно. Ийнхүү тогтмол хугацаанд бус, зөвхөн шаардлага гарсан тохиолдолд болох хурлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал гэнэ. Ээлжит бус хурлыг заавал хийх тодорхой нөхцөлүүд байдаг (Зураг 2)⁶.

⁵ Компанийн тухай хууль 73 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

⁶ Компанийн тухай хууль 61 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг



Зураг 2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах нөхцөл

Эдгээрээс гадна компанийн ТУЗ-өөс тодорхой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулж, шийдвэр гаргах нь зүйтэй гэж үзсэн тохиолдолд ээлжит бус хурлыг ТУЗ хэдийд ч зарлан хуралдуулж, ХЭХ-ын бүрэн эрхэд хамаарах асуудлыг шийдвэрлүүлж болно. Шаардлагатай гэж үзвэл ээлжит бус хурлыг жилд хэдэн ч удаа хуралдуулж болно.

 Санамж

Ээлжит бус хуралд хувьцаа эзэмшигчид өөрийн биеэр болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож болохоос гадна компанийн саналын хуудсанд заасан асуудлаар саналаа илгээх замаар оролцож болно. Эдгээрийн аль ч хэлбэрээр оролцсон түүнийг хуралд оролцсон гэж үзэж хурлын ирцэд оруулан тооцдог.

1.3. ХОЙШЛОГДСОН ХУРАЛ

Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид ХЭХ-д оролцоогүй бол уг хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн хойшлуулж, хуралдах өдрийг дахин товлодог. Ийнхүү дахин хуралдахаар зарласан хурлыг хойшлогдсон хурал гэнэ.

Хойшлогдсон хурал нь бусад хуралтай харьцуулахад дараах онцлогтой. Үүнд:



Хойшлогдсон хурлаар өмнө зарлагдсан хурлын асуудлыг хэлэлцнэ. Өөрөөр хэлбэл, хойшлогдсон хурлын хэлэлцэх асуудлыг өмнө төлөвлөснөөс өөрчилж болохгүй.



Хойшлогдсон хурлын ирц нь компанийн дүрмээр илүү өндөр хувь тогтоогоогүй бол саналын эрхтэй хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хүчин төгөлдөр болно.



Компанийн дүрмээр илүү өндөр хувь тогтоогоогүй бол компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах, компанийг нийлүүлж нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулах, өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, компанийн хэлбэрийг өөрчлөх, компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох, хувьцааг хуваах, нэгтгэх зэрэг асуудлыг хэлэлцэх хойшлогдсон хурал нь саналын эрхтэй хувьцааны гуравны нэгээс доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор хүчин төгөлдөр болно.



Хойшлогдсон хурал зарласнаас хойш ажлын 20 хоногийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал болохоос ажлын 7-оос доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.



Хойшлогдсон хуралд өмнө нь тогтоосон хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй.



Хүчин төгөлдөр бус гэж үзсэн хувьцаа эзэмшигчдийн өмнөх хуралд ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дүнд оруулан тооцдог.

 Санамж

Хувьцаа эзэмшигчдийн хойшлогдсон хурал нь зарласан хугацаандаа хуралдаж чадаагүй бол шинээр хурал зарлах бөгөөд энэ хурлыг хойшлогдсон хурал гэж үзэхгүй.

1.4.ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР ШИЙДВЭР ГАРГАХ

ХЭХ-ын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэх боломжийг Компанийн тухай хуулиар олгосон⁷. Энэхүү эчнээ санал хураалт нь хувьцаа эзэмшигчид бүрэн эрхийнхээ хүрээний асуудлаар хамтран шийдвэр гаргадгаараа хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын нэг төрөлд хамаарах бөгөөд түүнийг саналын хуудас ашиглан явуулдаг. Харин хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хуулиар хориглодог.

Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэрт Зураг 3-т үзүүлсэн зүйлийг заавал тусгана.



Зураг 3. Эчнээ санал хураалт явуулах шийдвэрт тусгах зүйл

⁷ Компанийн тухай хууль 73 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

Эчнээ санал хураалтын саналын хуудсанд Компанийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.4.1, 71.4.3-71.4.5-д заасан мэдээллийг тусгахын зэрэгцээ саналын хуудсыг хүлээн авах сүүлийн өдрийг заавал тусгана. Хувьцаа эзэмшигчид саналын хуудсаа эчнээ санал хураахаас 30-аас доошгүй ажлын өдрийн өмнө хүлээн авсан байхаар компанийн зүгээс зохион байгуулалт хийх шаардлагатай. Ялангуяа олон хувьцаа эзэмшигчтэй, тэд орон даяар тархан амьдардаг бол энэ хугацаа урт байх нь зүйтэй.

 Санамж

Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудал нь нэгээс ихгүй байх нь зохимжтойгоос гадна санал өгөхөд хялбар, гаргасан шийдвэр нь сөрөг үр дагавар гаргах эрсдэл багатай асуудал байх нь зүйтэй. Үүнээс гадна зарим оронд эчнээ санал хураалтаар шийдвэрлэхийг хориглосон асуудлыг хуулиар тусгайлан тогтоосон байдаг. Жишээ нь, Оросын Холбооны Улсад ТУЗ-ийн гишүүдийг томилох, аудитын компанийг сонгох, жилийн тайланг батлах, ногдол ашиг хуваарилах зэрэг асуудлыг эчнээ санал хураалтаар шийдвэрлэхийг хориглодог байна.⁸ Манай орны хувьд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулан шийдвэр гаргахыг Компанийн тухай хуулиар хориглосон.

Эчнээ санал хураалтаар ХЭХ-ын бүрэн эрхийн хүрээний асуудлыг шийдвэрлэхэд оролцох хувьцаа эзэмшигчид болон шийдвэр гаргах ирц нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай адил байдаг. Эчнээ санал хураалтаар ирүүлсэн саналыг тоолж, дүнг гаргахад ТУЗ-өөс тусгайлан томилсон Тооллогын комисс ажиллана. Тооллогын комисс нь саналын хуудсыг хүлээн авсан сүүлийн өдрөөс хойш ажлын гурван өдөрт багтаан эчнээ санал хураалтын дүнг гаргана. Ингэхдээ Зураг 4-т дурдсан асуудлуудыг тусгасан тайлан гаргаж, ТУЗ-д хүргүүлнэ.

⁸ Пункт 2 статьи 50 Закон об АО



Зураг 4. Эчнээ санал хураалтын дүнгийн тайланд тусгах зүйл

ТУЗ Тооллогын комиссын тайланг үндэслэн эчнээ санал хураалтын дүнгийн талаар шийдвэр гаргаж, үр дүнг тайлан хүлээн авснаас хойш ажлын долоо хоногт багтаан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх үүрэгтэй.

1.5. НЭГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧТЭЙ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН БҮРЭН ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ОНЦЛОГ

Нэг хувьцаа эзэмшигчтэй компанид ХЭХ гэсэн удирдлагын бүтэц байхгүй ч хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой зохицуулалт шаардлагатай. Энэ талаар Компанийн тухай хуульд “Нэг хувьцаа эзэмшигчтэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хувьцаа эзэмшигч өөрөө хэрэгжүүлнэ”⁹ гэж заасан байна. Өөрөөр хэлбэл, хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийн асуудлаар тухайн нэг хувьцаа эзэмшигч өөрөө шийдвэр гаргана гэсэн үг юм. Нэг хувьцаа эзэмшигчийн шийдвэр гаргах үйл ажиллагааны талаар хуульд тодорхой зохицуулалт байхгүй тул энэ төрлийн компани ХЭХ-ын бүрэн эрхийг хэрхэн хэрэгжүүлэх талаар үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг болох өөрийн дүрэмдээ тусгайлан зохицуулах замаар энэхүү ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Дүрмийн энэхүү зохицуулалтад дараах зүйлийг тодорхой тусгасан байвал зохино. Үүнд:



Шийдвэр гаргах эрх бүхий хувьцаа эзэмшигчийн оноосон нэр (хэрэв хувь хүн бол түүний овог, нэр, регистрийн дугаар; хуулийн этгээд бол хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар шийдвэр гаргах эрх бүхий удирдлагын бүтцийн нэр; төр бол төрийг төлөөлж буй хувьцаа эзэмшигч этгээдийн нэр).



Гаргах шийдвэрийн төрөл (тушаал, тогтоол, захирамж зэргийн аль нь байх).



Дээр дурдсан оноосон нэрийн өмнө “...компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч” гэсэн тодруулгыг оруулсан байх тухай шаардлага.

⁹ Компанийн тухай хууль 59 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

> Энэхүү шийдвэрийг гаргахдаа тухайн этгээдийн шийдвэр гаргах журмыг баримтлах шаардлага.

> Хувьцаа эзэмшигчийн хурлын бүрэн эрхийн хүрээний асуудлаар шийдвэр гаргах ажиллагааг ХЭХ хуралдуулах журмын дагуу явуулах шаардлага.

> ХЭХ-ын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нэг хувьцаа эзэмшигч нь хурлын бүрэн эрхийн хүрээний асуудлаар шийдвэр гаргахдаа зөвхөн компанийн ТУЗ /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ - өөс ирүүлсэн саналыг үндэслэх ба хэрэв өөрөө шийдвэр гаргах шаардлагатай тохиолдолд энэ талаарх саналаа ТУЗ /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-д хүргүүлэн түүний саналыг үндэслэн шийдвэр гаргах шаардлага.

2. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН БҮРЭН ЭРХ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

ХЭХ-ын бүрэн эрхийг хуулиар тогтоосон байдаг¹⁰ ба энэхүү бүрэн эрхийг компанийн дүрэм болон эрх зүйн бусад актаар өөр этгээдэд шилжүүлэхийг хориглодог. Харин зарим оронд ХЭХ өөрөө боломжтой гэж үзсэн тодорхой эрхийг зөвхөн ТУЗ-д тодорхой хугацаанд шилжүүлж болох практик байдаг. Манай орны хувьд одоогоор ийм практик байхгүй. Харин хууль зүйн нийтлэг жишгээр эрх бүхий этгээд өөрийн бүрэн эрхээ өөр этгээдэд тодорхой нөхцөл, хугацаагаар шилжүүлж болдог. Хэрэв ХЭХ-аас зөвшөөрвөл хувьцаа эзэмшигчдийн хурлын зарим бүрэн эрхийг ТУЗ хэрэгжүүлэх бололцоотой.

Компанийн тухай хуульд заасны дагуу ХЭХ нь дараах бүрэн эрхтэй. Үүнд:



компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах



нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах



компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох

¹⁰ Компанийн тухай хууль 62 дугаар зүйл



компанийн хэлбэрийг өөрчлөх



компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох



хувьцааг хуваах, нэгтгэх



төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох

Эдгээрээс гадна ХЭХ-аар ТУЗ-ийн шийдвэрээр хэлэлцүүлэхээр оруулсан асуудал болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудлыг ХЭХ-аар хэлэлцэн зохих шийдвэр гаргаж болдог.

3. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН БЭЛТГЭЛ ХАНГАХ

Аливаа хурлын гол хэсэг нь хуралдааны ажиллагаа байдаг бол ХЭХ-ын хувьд хурлын бэлтгэл хангах нь хамгийн чухал хэсэг юм. Учир нь ХЭХ-д хувьцаа эзэмшигчид заавал өөрийн биеэр ирж оролцохгүйгээр, хэлэлцэж буй асуудлаар компаниас явуулсан саналын хуудсыг бөглөн санал ирүүлэх замаар оролцох бололцоотой байдаг тул бусад ердийн хурал дээр хийгддэг олон ажиллагаа нь хурлын бэлтгэл ажлыг хангах шатанд хийгддэг. Хурлын бэлтгэл ажлын хүрээнд хурал хуралдуулах, санал гаргах, хэлэлцэх асуудлыг тогтоох, хурал хуралдах тухай шийдвэр гаргах, зар хүргэх, саналын хуудсын агуулгыг зөв гаргах, түүнийг хувьцаа эзэмшигчдэд цаг тухайд нь хүргэн саналыг нь авч буцаагаад компанид хугацаанд нь ирүүлэх болон хурлыг хуралдуулах зэрэг ажиллагаа хамрагддаг. Эдгээр нь тодорхой хууль, дүрэм, журмаар зохицуулагдсан үе шат, дэс дарааллын дагуу явагдах ёстой ажиллагаа юм.

Эдгээр ажиллагааг тус бүрээр дэлгэрүүлж авч үзье.

3.1. ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ САНАЛ ГАРГАХ

ХЭХ-ын бэлтгэл хангах нь хурал хуралдуулах тухай санал гаргахаас эхэлнэ. Тодорхой тогтсон хугацаанд хийх учиртай хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухайд өмнө нь санал гаргах шаардлагагүй. Харин зайлшгүй хэлэлцэн шийдвэрлэх асуудал үүсэх тохиолдолд ээлжит бус хурал зарлан хуралдуулах санал гаргана.

☒ **Санамж**

ХЭХ хуралдуулах нь хүн хүч, цаг хугацаа, хөрөнгө мөнгө шаардах нарийн төвөгтэй ажиллагаа байдаг тул дэлхийн аль ч оронд энэхүү санал гаргах ажиллагааг тодорхой хэмжээнд хязгаарласан байдаг. Өөрөөр хэлбэл, дурын хувьцаа эзэмшигч болон бусад аливаа гуравдагч этгээд ээлжит бус хурал хуралдуулах санал гаргах бололцоогүй гэсэн үг. Манай орны хувьд энэхүү санал гаргах эрхийг ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, аудитын хороо, ТУЗ болон компанийн нийт гаргасан хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигчдэд олгосон байна.¹¹ Ийнхүү санал гаргах этгээдийг хуулиар тогтоосноос гадна хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах нөхцөлийг тогтоож өгсөн нь дурын этгээд, хүссэн бүхий л асуудлаар ХЭХ-ыг хуралдуулах санал гаргах бололцоогүй болгож байгаа юм.

Хурал хуралдуулах тухай санал гаргагч нь Компанийн тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, аудитын хороо, ТУЗ болон компанийн нийт гаргасан хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигчид байна. Эдгээр этгээд нь ээлжит бус хурал хуралдуулах саналаа бичгээр гаргах ба түүндээ Зураг 5-д заасан зүйлийг тусгасан байна.

¹¹ Компанийн тухай хууль 61 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт



Зураг 5. Ээлжит бус хурал хуралдуулах саналд тусгах зүйл

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах санал гаргах хуудасны загварыг Хавсралт 1-д харуулав.

Санал гаргагч этгээд нь дээрх саналаа компанийн ТУЗ-д ирүүлэх ба ТУЗ уг саналыг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан ХЭХ-ыг хуралдуулах эсэх талаар шийдвэр гаргаж, санал гаргагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. ТУЗ энэхүү үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд санал гаргагч этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэрийг бие даан гаргах эрхийг хуулиар олгожээ.¹² Энэ тохиолдолд хурал зарлах, хуралдуулахтай холбогдсон зардлыг компани хариуцна.

¹² Компанийн тухай хууль 61 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг

ТУЗ дор дурдсанаас бусад тохиолдолд ХЭХ хуралдуулахаас татгалзах эрхгүй. Үүнд:



Санал гаргасан этгээд нь хувьцаа эзэмшигч бөгөөд түүний эзэмшиж буй хувьцааны саналын эрх нь нийт саналын эрхтэй хувьцааны 10 хувьд хүрээгүй.



Хурлаар хэлэлцүүлэх асуудал нь ХЭХ-ын бүрэн эрхэд хамаарахгүй.

Хэрэв ТУЗ-өөс хурал хуралдуулахаас татгалзсан шийдвэр гаргасан бол санал гаргасан этгээд энэхүү шийдвэрийн талаар шүүхэд гомдол гаргах эрхтэй.

3.2.ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

Аливаа хуралд өөрийн биеэр оролцох үед хэлэлцэх асуудлаа хурал дээрээ шууд ярилцан шийдвэрлэх бололцоотой байдаг бол ХЭХ-д оролцогчид заавал биеэр оролцох албагүй. Харин эрхзүйн хувьд саналын хуудсаар дамжуулж оролцох бололцоотой учир хэлэлцэх асуудлыг хурал дээрээ шууд шийдвэрлэх боломжгүй. Үүнтэй уялдан Компанийн тухай хуульд ТУЗ-өөс ХЭХ хуралдуулах тухай шийдвэртээ тухайн хурлаар хэлэлцэх асуудлыг тогтоож өгөх,¹³ мөн энэхүү тогтоосноос өөр асуудлыг ХЭХ-аар хэлэлцэхийг хориглох зохицуулалтыг тусгасан байна.¹⁴ Иймээс ХЭХ-аар хэлэлцэх асуудлыг хурлын өмнө ТУЗ-өөс гаргаж байгаа хурал хуралдуулах шийдвэртээ тогтоож өгөх бөгөөд ийнхүү тогтоосноос өөр асуудлыг хэлэлцэхгүй. Хэрэв ХЭХ болж байх үед хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн бол уг шийдвэрийг хүчин төгөлдөр бус гэж үзнэ. Цаашилбал, тухайн хурлыг ч хүчин төгөлдөр биш гэж тооцох үндэслэл үүсдэг учир зөвхөн хэлэлцэх асуудлын жагсаалтад багтсан асуудлыг л хэлэлцэх нь зүйтэй.

¹³ Компанийн тухай хууль 60 дугаар зүйлийн 2.2 дахь заалт

¹⁴ Компанийн тухай хууль 63 дугаар зүйлийн 10 дахь хэсэг

ХЭХ-аар хэлэлцэх асуудал нь түүний бүрэн эрхийн хүрээний асуудал байх бөгөөд үүнээс өөр асуудлыг хэлэлцэхгүй. Ер нь компанийн засаглалын нийтлэг зарчмаар компанийн удирдлагын бүтцүүдийн эрх үүргийг тус бүрд нь тодорхойлон зааглаж өгсөн байдаг. ХЭХ-ын хэлэлцэх асуудал ч энэхүү заагаар хязгаарлагдана.

ХЭХ-аар хэлэлцэх асуудалд хувьцаа эзэмшигч болон ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, хөндлөнгийн аудитороос санал ирүүлэх бололцоотой. Санал гаргагч нь хэлэлцэх асуудалд оруулах саналаа ХЭХ-ыг хуралдуулах саналын хамт ТУЗ-д хэдийд ч ирүүлж болно. Ирүүлсэн санал нь ХЭХ-ын бүрэн эрхийн хүрээний асуудал бол ТУЗ түүнийг хурлын хэлэлцэх асуудалд оруулан товоо зарлаж, хуралдуулах үүрэгтэй.

3.2.1. Ээлжит хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах

Саналын эрх бүхий энгийн хувьцааны тав буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл нэгдмэл сонирхол бүхий этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч этгээд ХЭХ-ын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон ТУЗ, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх хүний талаарх саналаа санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор ТУЗ, эсхүл гүйцэтгэх удирдлагад гаргаж болно. Хувьцаа эзэмшигч энэхүү саналаа бичгээр гаргах бөгөөд уг бичигт гаргаж буюу санал, түүний үндэслэл, санал оруулж байгаа хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, эзэмшиж буй хувьцааны төрөл, тоог тусгасан байна. Гүйцэтгэх удирдлага ирүүлсэн саналыг ТУЗ-д ажлын гурван өдөрт багтаан хүргүүлэх үүрэгтэй. Тэрхүү санал нь ХЭХ-ын бүрэн эрхийн хүрээний асуудал бол ТУЗ түүнийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулан шийдвэрлүүлэх үүрэгтэй. Хэрэв татгалзсан бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг санал гаргасан хувьцаа эзэмшигчид хүргүүлнэ. Энэхүү шийдвэрийн талаар санал гаргагч шүүхэд гомдол гаргах эрхтэй ба ТУЗ санал гаргагчийн зөвшөөрөлгүйгээр түүний саналыг өөрчлөх эрхгүй.

3.3.ХУРАЛД ОРОЛЦОХ ЭРХТЭЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ ТОДОРХОЙЛОХ

ХЭХ хуралдах тухай шийдвэр гарсан өдөр ба хурал болох өдрийн хооронд бэлтгэл хангах зэргээс шалтгаалан олон өдрийн зөрүү гардгийг энэхүү гарын авлагын Схем 1-д тодорхой дурдсан ба энэ хугацаанд хувьцаа эзэмшигчид өөрчлөгдөх бололцоотой. Үүнтэй холбогдуулан тухайн хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдийн нэрийг гаргах “бүртгэлийн өдөр” гэдэг ойлголт үүсдэг. Энэ нь хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрийг хурал зарлагч этгээдээс тогтоосон өдрөөр тасалбар болгосон өдөр юм. Уг өдрийг хурал зарлагч этгээд хурал хуралдуулах тухай шийдвэртээ тогтоож өгдөг. “Бүртгэлийн өдөр”-ийг хурал хуралдуулах шийдвэр гаргасан өдрөөс өмнө байхыг хуулиар хориглодог. Энэ нь шийдвэр гарсан өдөр болон түүнээс өмнө хувьцаа эзэмшиж байсан хувьцаа эзэмшигчийн хуралд оролцох эрхийг хамгаалах зорилготой юм.

Мөн хурал зарлагч нь тухайн хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрийн жагсаалтыг хувьцаа эзэмшигчдийн бүртгэл хөтлөгч этгээд /компани өөрөө эсхүл үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд/-ээс дээр дурдсаны дагуу тогтоосон бүртгэлийн өдрөөр тасалбар болгон гаргуулан авч хурлын мэдээлэл хүргэх, ирц болон шийдвэр гаргах зэрэгтээ ашигладаг. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийн талаарх мэдээллийг ХЭХ-ын зард тодорхой зааж өгч, нийтэд мэдээлнэ. Энэхүү мэдээлэл нь тухайн компанийн хувьцаа эзэмшигчид болон сонирхож буй хөрөнгө оруулагчдад чухал мэдээлэл болдог.

Хувьцаа эзэмшигчдийн бүртгэл хөтлөгчийн талаар энэхүү гарын авлагын “Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийг бүртгэх” гэсэн хэсгийн санамжаас дэлгэрүүлэн уншина уу.

3.4. ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ШИЙДВЭР ГАРГАХ, ХУРЛЫН ТОВ ТОГТООХ

ХЭХ-ын бэлтгэл ажлын нэг чухал хэсэг нь хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах явдал. Уг хуралыг хувьцаа эзэмшигчид зарлах эрхгүй ба энэхүү эрхийг компанийн ТУЗ хэрэгжүүлэхээр хуульчилсан¹⁵. Иймд ХЭХ-аар хэлэлцэн шийдвэрлэх асуудал үүссэн тохиолдолд хурлыг зөвхөн ТУЗ зарлан хуралдуулдаг. Үүний шалтгаан нь хувьцаа эзэмшигчид компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдоггүй учраас компани дээр ХЭХ хуралдуулах шаардлага гарч байгаа эсэхийг тэр бүр мэдэхгүйгээс гадна олон хувьцаа эзэмшигчдээс өөр өөр чиглэлийн санал, хүсэлт гарах боломжтой тул тэдний хувьд хурал хуралдуулах эсэх талаар нэгдсэн шийдвэр гаргах зохион байгуулалтад орох бололцоо бага байдагтай холбоотой.

Харин Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2-т саналын эрх бүхий нийт хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшигчид хурал хуралдуулах талаар ТУЗ-д санал, шаардлага гаргах эрхийг олгосон. Энэхүү санал, шаардлага нь ХЭХ-ын бүрэн эрхийн хүрээний асуудал бол санал авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор ХЭХ-ыг зарлан хуралдуулах шийдвэр гаргах үүргийг ТУЗ-д хуулиар хүлээлгэсэн байна.¹⁶ Хуулийн дээрх зохицуулалтын дагуу хувьцаа эзэмшигчид ХЭХ-ыг хуралдуулах шууд эрхгүй ч хуралдуулах тухай санал гаргах эрхтэй. Харин ТУЗ уг саналын дагуу ХЭХ-ыг заавал хуралдуулах үүрэг хүлээдэг.

Эдгээрээс гадна ТУЗ энэхүү үүргээ хэрэгжүүлээгүй бол санал, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчид ХЭХ-ыг шууд зарлан хуралдуулж болох ба тэдгээртэй холбогдсон зардлыг компани хариуцахаар хуульд заажээ.¹⁷ Хуульд ийм зохицуулалт орсноор хувьцаа эзэмшигчид ХЭХ-ыг шууд зарлах эрхгүй ч хурал хуралдуулах талаар санал гаргах замаар шаардлагатай үедээ ХЭХ-ыг хуралдуулах эрхээ эдлэх нөхцөл бүрдсэн гэж үздэг.

¹⁵ Компанийн тухай хууль 60 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

¹⁶ Компанийн тухай хууль 61 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг

¹⁷ Компанийн тухай хууль 61 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг

ХЭХ-ыг хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрт дараах зүйлийг тусгана.
Үүнд:

> Хурал болох газар, өдөр, цаг

> Хэлэлцэх асуудал

> Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр

> Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчиддэд мэдэгдэх журам;

> Бэлтгэлийн явцад хувьцаа эзэмшигчидийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт

> Саналын хуудасны агуулга

> Саналын хуудсыг хүлээн авах сүүлийн өдөр

> Хурлын дарга

> Тооллогын комиссын дарга, гишүүд

ТУЗ хурал хуралдуулах тухай шийдвэртээ дээр дурдсан асуудлуудыг тодорхой заахгүй орхивол тухайн асуудал хэрэгжихгүй орхигдох, маргаан үүссэн тохиолдолд шийдвэрлэх боломжгүй болох, субъектив хандлагаар асуудалд хандах эрсдэл үүсэх ба энэ нь компанийн болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг эрх, ашиг сонирхолд сөрөг үр дагавар үүсэх нөхцөл болж болзошгүй юм. Иймд ТУЗ нь ХЭХ-ыг

хуралдуулах шийдвэрт дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэх арга замыг дэлгэрэнгүй, тодорхой, ойлгомжтой тусгах нь чухал бөгөөд энэ нь эцсийн дүндээ ХЭХ хуульд заасан журмын дагуу явагдаж, шийдвэр гаргах үндсэн суурь нь болно.

ХЭХ-ын аль ч хэлбэрийн хувьд хувьцаа эзэмшигчид хурлын материалыг хүлээн авч танилцах, биечлэн оролцох, эсвэл саналын хуудсыг бөглөж ирүүлэх хугацаа зэргийг тооцож, ТУЗ-өөс ХЭХ-ын товыг гаргана. Уг хурлын тов нь шийдвэр гарсан өдрөөс хойш 40-өөс доошгүй хоног байхаар тогтоож, хурлын зарыг энэхүү шийдвэр гарсан өдрөөс тав хоногийн дотор нийтэд зарлаж байхаар хуульчилсан¹⁸. Иймд ХЭХ хуралдуулах шийдвэр гаргах ТУЗ-ийн хурлыг хуралдуулах хугацаа болон ХЭХ-ын товыг тогтоох зэрэгт дээр дурдсан хугацааг нарийн тооцоолж ажиллах нь туйлын чухал юм.

Санамж

ХЭХ-ыг гол төлөв компанийн төв байранд хийхээр зарласан байдаг боловч байрны багтаамж, байршил болон хувьцаа эзэмшигчдийн тооноос хамаарч өөр газар хийх тохиолдол ч гардаг. Ямар ч тохиолдолд хурал болох газрыг сонгохдоо хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн зүгээс аль болох бага зардал гаргах, олон хувьцаа эзэмшигч оролцох бололцоог хангах, хурал болох газрын байршил, хаяг нь хүмүүст ойлгомжтой, олж очиход хялбар байх, нийтийн тээврийн хэрэгслээр зорчин очих боломжтой байх зэрэг асуудлуудыг анхаарах нь зүйтэй. Түүнчлэн орчин үед байшин барилгууд нь олон давхар, нүсэр том болж, түүнд нэвтрэхэд тодорхой шаардлага тавигдах болсонтой холбогдуулан ийм байр сонгосон тохиолдолд ХЭХ болох өрөө, танхимд саадгүй нэвтрэн орох бололцоог хангах хэрэгтэй. Зарим тохиолдолд хурал болох газрын хаяг нь тодорхой боловч түүнд орох бололцоог хангаагүйгээс хувьцаа эзэмшигчид хурал болох өрөө тасалгаанд орж чадахгүй буцах тохиолдол ч гардгийг анхаарах хэрэгтэй.

¹⁸ Компанийн тухай хууль 60 дугаар зүйлийн 3 дахь хэсэг

3.5.ХУРЛЫН ЗАР ХҮРГЭХ

ХЭХ-ын зарыг шийдвэр гарснаас хойш хурал зарлагч тав хоногийн дотор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэх үүрэгтэй. Энэхүү мэдээллийг хүргэх олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэдэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын 3.3-т “...өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр, компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудас” зэргийг хамааруулахаар заасан байна. Харин ХЭХ-ын зарыг хэд хэдэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэг өдөр, нэгэн зэрэг мэдээлэх шаардлагатай ба хэрэв өөр өөр өдөр зарласан бол “нийтэд хүргэсэн өдөр”-ийг тооцохдоо Хөрөнгийн биржийн цахим хуудсаар мэдээлсэн өдрийг тооцохоор дээрх журмын 3.6-д заасан. Эдгээрээс гадна хувьцаа эзэмшигч болон бусад хөрөнгө оруулагчдын мэдээлэл авч хамгийн шуурхай болох хэрэгсэл бол тухайн компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудас тул хурлын зарыг түүнд байршуулах нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад мэдээлэл түргэн шуурхай, хүртээмжтэй хэлбэрээр хүрэх ач холбогдолтой юм. Харин цөөн тооны хувьцаа эзэмшигчтэй компанийн хувьд хурлын зарыг биечлэн хүргэх, эсвэл утас, факс, электрон шуудан зэрэг холбоо харилцааны боломжит бусад хэрэгслийг ашиглаж болно. Аль ч тохиолдолд хувьцаа эзэмшигчдэд хурлын зар хүргэснээ баримтжуулж, ХЭХ-ын тайланд хавсаргах нь зүйтэй.

ХЭХ-ын зард дараах мэдээллийг заавал тусгана. Үүнд:



Компанийн оноосон нэр, байршил, хурал болох өдөр, цаг, газар



Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр



Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт

> Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг

> Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн утас, электрон шуудангийн хаяг

> Компанийн дүрэмд заасан болон хурал зарлагч этгээдээс шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл

> Саналын хуудсыг хүлээн авах газар, сүүлийн хугацаа

☒ Санамж

ХЭХ-ын зарыг хэрхэн хүргэснээс хурлын ирц шууд хамаарах тул зар хүргэх арга, хэлбэр, хүрээг хувьцаа эзэмшигчдийн онцлогт тохируулан маш оновчтой сонгох нь чухал байдаг.

Хувьцаа эзэмшигч олонтой компанийн хувьд хурлын зарыг дээр дурдсан олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хэд хэдэн удаа хүргэхээс гадна сонин хэвлэлд нийтлэхдээ хүмүүст шууд харагдах байршлыг сонгох хэрэгтэй. Радио, телевизийн хувьд оргил цагийг сонгох нь мөн чухал байдаг. Эдгээрээс гадна олон хувьцаа эзэмшигч амьдардаг газар нутагт мэдээллийг тусгайлан явуулах нь үр дүнтэй. Мөн сүүлийн үед манай компаниудын хувьцааг гадаадын иргэд, хуулийн этгээд эзэмших болсонтой холбогдуулан мэдээлэл хүргэх хэлийг зөв сонгоход анхаарах нь зүйтэй юм.

Хувьцаа эзэмшигчдэд хүргэх хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой танилцуулга болон бусад шаардлагатай мэдээлэл хүргэхэд хэрэглэх “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар болон хурлын материал хүргүүлж байгаа тухай мэдээлэх хуудас”-ны загварыг Хавсралт 2-т үзүүлэв.

ХЭХ-ын ирц сайн байх, хурлын шийдвэрээ оновчтой, зөв гаргахад хувьцаа эзэмшигчдэд хүргэх хурлын материал маш чухал. Уг материалд хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл, тэдгээртэй

холбогдох тайлбар, танилцуулга, саналын хуудас болон бусад шаардлагатай баримт материал хамаарах бөгөөд тэдгээрийн жагсаалтыг ТУЗ-өөс хурал хуралдуулах тухай шийдвэр гаргахдаа тогтоож өгдөг. ТУЗ-өөс хувьцаа эзэмшигчдэд хүргэхээр баталсан хурлын материалыг хүргэх ажлыг хурал зарлагч этгээд зохион байгуулж, холбогдох зардлыг компани хариуцан гаргана.

Хувьцаат компанийн ХЭХ-ын зар, холбогдох баримт, материалыг хувьцаа эзэмшигчдэд хүргэхтэй холбоотой харилцааг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 444 дүгээр тогтоолоор баталсан журмаар зохицуулдаг бол төрийн өмчийн компанийн энэ төрлийн харилцааг нарийвчлан зохицуулсан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ, тогтоосон журам байхгүй байна. Гэсэн хэдий ч хурал зарлагч нь тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо, байршил, тархалт зэрэгтэй уялдуулан, холбогдох шийдвэр гарган зохион байгуулах шаардлагатай.

Тухайн компани нь цөөн тооны хувьцаа эзэмшигчтэй бөгөөд тэдгээр нь компанийн төв захиргаа байршин буй нутаг дэвсгэрт байдаг бол хурлын материалыг шууд өөрт нь хүргэх, хэрэв боломжгүй бол шуудангаар, эсхүл цахим хаягаар хүргэх нь илүү зохимжтой. Харин олон хувьцаа эзэмшигчтэй бөгөөд тэдгээр нь компанийн төв захиргаа байршин буй газраас өөр өөр газар, орон нутагт амьдардаг бол хувьцаа эзэмшигчдэд зуучлах үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий брокер, дилерийн компанитай гэрээ байгуулж, түүгээр дамжуулан хурлын материалыг танилцуулж санал авах ажлыг зохион байгуулдаг. Үүнийг илүү оновчтой бөгөөд хувьцаа эзэмшигчдэд чирэгдэл багатай зохион байгуулах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмын 3.10-т зааснаар “Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг хурлын зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 5 хоногт багтаан хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компанид хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлнэ” гэж заасан байдаг. Харин цаашид Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд зааснаар хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг үнэт цаасны төвлөрсөн ба тухайлсан бүртгэлийн хэлбэрт шилжүүлж, улмаар тухайлсан бүртгэлийг кастодиан банкууд гүйцэтгэснээр хувьцаа эзэмшигчдэд ХЭХ-ын зар хүргэх, хурлаар хэлэлцэх асуудлаар санал өгөх, хуралд оролцох зэрэг асуудлууд ихээхэн хялбар болдог. Ингэснээр хувьцаа эзэмшигчид эрхээ бүрэн хэрэгжүүлэх боломжтой болох юм.

 Санамж

Хурлын материалыг хувьцаа эзэмшигчдэд хүргэх нэг чухал арга зам нь компани өөрийнхөө цахим хуудсанд байршуулан хувьцаа эзэмшигчдэдээ мэдээлэх замаар танилцуулах явдал бөгөөд энэ нь хамгийн хялбар, хямд бөгөөд үр өгөөжтэй хэлбэр юм. Гэхдээ уг хэлбэр нь том компаниудад илүү хамааралтай бол компанийн үйл ажиллагааны цар хүрээ бага, хөдөө орон нутаг, суманд үйл ажиллагаа явуулдаг, цөөн тооны ажилтантай компанийн хувьд цахим хуудас тогтмол ажиллуулах, түүгээр дамжуулан мэдээлэл түгээх зэрэг нь хүндрэлтэй байж болох юм. Иймд Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчид болон нийтэд хурлын талаарх мэдээллийг хүргэх нь илүү хүртээмжтэй, шуурхай байдаг. Аль ч тохиолдолд ХЭХ-ын материалыг компани өөрийн төв байранд тодорхой өрөө гарган байршуулж, хувьцаа эзэмшигч болон бусад сонирхогч талууд танилцах бололцоогоор хангах нь зүйтэй.

3.6.САНАЛЫН ХУУДАС, ТҮҮНИЙ БҮТЭЦ

Саналын хуудсанд тухайн хурлаас гарах шийдвэрийн төсөл бичигдсэн байх бөгөөд хувьцаа эзэмшигчид шийдвэрийн төсөлтэй танилцан түүнийг зөвшөөрөх эсэх талаар саналын хуудсанд дурдсан тэмдэглэгээг хийж буцах хаягаар нь илгээнэ. Энэхүү илгээсэн саналын хуудсыг ХЭХ-ын тооллогын комисс хүлээн авч, хурлын ирц болон шийдвэр гаргах зэрэгт ашиглана. Энэ утгаараа саналын хуудас нь нэг талаас хувьцаа эзэмшигчдийн хувьд хуралд оролцож саналаа өгөх хэлбэр, нөгөө талаас хурлын шийдвэр гаргахад хамгийн чухал хэрэгсэл болдог. Тухайн хурлын хэлэлцэх асуудал болон бусад онцлогоос хамааран саналын хуудасны агуулга, доторх бичвэрийг хурал зарлагч этгээд бэлтгэн ТУЗ-өөр тухайн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед нь тохирох саналын хуудсыг тусгайлан батлуулдаг.

Саналын хуудсанд дараах зүйлийг тусгана.

> Саналын хуудсыг баталсан шийдвэрийн нэр

> Тухайн компанийн оноосон нэр

> Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах газар, сар, өдөр, цаг;

> Хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар;

> Эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо;

> Санал хураалтаар шийдвэрлэх асуудлын томьёолол /хурлаас гаргах шийдвэрийн төсөл/;

> ТУЗ-ийн гишүүнийг сонгох бол түүнд нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;

> ТУЗ-ийн гишүүдийг сонгоход хэрэглэх санал хураах аргын төрөл /ердийн эсхүл кумулятив/;

> Саналын хуудсыг бөглөх зааварчилгаа

Компанийн сайн засаглалын зарчимд ТУЗ-ийн гишүүнийг санал хураах кумулятив аргаар сонгох нь зүйтэй гэж үздэг бөгөөд үүнтэй холбогдуулан Компанийн тухай хуулийн 77.4-т “Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар сонгоно” гэж заажээ. Мөн уг хуулийн 72.1.3-т “кумулятив аргаар санал хураан сонгох тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч тус бүрд өгсөн саналын тооны нийлбэр нь тухайн хувьцаа эзэмшигчийн саналын эрхийн тооны нийт дүнгээс илүүгүй байх бөгөөд саналын эрхийн тооны нийт дүн нь тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа саналын эрх бүхий энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна” гэж заасан. Энэ арга нь жижиг хувьцаа эзэмшигчид өөрсдийн төлөөллөө ТУЗ-ийн бүрэлдэхүүнд оруулах бололцоог хангахад ихээхэн ач холбогдолтой учраас дэлхийн ихэнх орон ТУЗ-ийн гишүүдийг сонгоход өргөн ашигладаг. Кумулятив аргыг хэрэглэх тохиолдолд уг аргын тухай тайлбар бүхий саналын хуудас хэрэглэхийг зөвлөж байна. “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудас”-ны загварыг Хавсралт 3-т үзүүлэв.

3.7. ХУРЛЫН ДАРГА

Аливаа хурал даргалагчаа хуралдааныхаа үеэр сонгодог бол ХЭХ-д оролцогчид нь саналын хуудас бөглөн ирүүлэх замаар оролцдог тул даргалагчийг хуралдааны үеэр сонгох бололцоогүй. Иймд ТУЗ хурал хуралдуулах шийдвэр гаргах үедээ тухайн ХЭХ-ыг удирдах даргыг урьдчилан томилдог. Энэ талаар Компанийн тухай хуулийн 59.10-т “Хувьцаа эзэмшигчдийн хурлыг удирдах этгээдийг тухайн хурлыг зарласан этгээд хурал хуралдуулах шийдвэрт заана” гэж дурдсан байна. Ийнхүү томилогдсон этгээд тодорхой шалтгааны улмаас ХЭХ-ыг даргалах боломжгүй болбол энэ тухайгаа ТУЗ-д мэдэгдэх ба ТУЗ хурал хуралдах өдрөөс өмнө даргыг дахин томилно. Хурлын дарга нь “Тооллогын комисс”-ын гаргасан ирцийн мэдээллийг үндэслэн хурлын хүчинтэй эсэхийг тодорхойлж, хурлын ажиллагааг удирдан явуулахаас гадна гарах шийдвэрийг хянан үзэж, гарын үсэг зурж баталгаажуулах ажлыг удирдан зохион байгуулна.

3.8. ТООЛЛОГЫН КОМИСС, ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХЭХ зарлагч этгээд хурал хуралдуулах тухай шийдвэрийг анх гаргахдаа "Тооллогын комисс"-ыг томилох бөгөөд уг комиссын үүргийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхээр тогтоож болохоос гадна хувьцаа эзэмшигчдийн бүртгэл хөтлөгч этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх боломжтой. Зарим оронд ийм үйлчилгээг дагнан хэрэгжүүлдэг мэргэшсэн зуучлагч компаниуд ажилладаг байна.

"Тооллогын комисс" нь хувьцаа эзэмшигчдийн ирүүлсэн саналын хуудсыг хүлээн авч, компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэл хөтлөгчөөс ирүүлсэн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн жагсаалттай тулган хурлын ирцийг тогтоох, хурлын явцад хэлэлцэх асуудал тус бүрээр хурлаас гарах шийдвэрт хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналыг тоолж дүнг гаргах зэрэг хамгийн чухал ажиллагааг гардан хэрэгжүүлдэг. Иймээс томоохон хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан болон бусад этгээдээс хамааралгүй, тэдний нөлөөлөлгүйгээр, бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлэх шаардлагатай. Иймд ХЭХ-ын хэлэлцэх асуудалтай шууд холбоотой компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийг хурлын "Тооллогын комисс"-ын гишүүнээр томилохыг Компанийн тухай хуулийн 67.2-т зааснаар хориглодог байна.

ХЭХ-ын тооллогын комисс дараах үүрэг хүлээнэ:

- > Хурлын ирц /кворум/-ийг тогтоож, хурлын даргад мэдээлэх.
- > Тухайн хурлын хэлэлцэх асуудал тус бүрээр оролцогч бүрийн саналын эрхийн тоо, төрлийг тогтоох.
- > ХЭХ-д оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах асуудалд тайлбар өгөх.
- > Санал өгөх журмыг тайлбарлах.
- > Санал өгөх журам болон хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах.
- > Саналын хуудсыг тоолж, хүлээн авах.
- > Санал хураалтын дүнгийн талаар тэмдэглэл хөтлөх.
- > Санал тоолж, дүнг нэгтгэж, дүнгийн тухай шийдвэр гарган тооллогын комиссын дарга гарын үсэг зурж, хуралд танилцуулах.
- > Саналын хуудсыг компанийн архивд хадгалуулахаар шилжүүлэх.

Үүнээс гадна ТУЗ-өөс ХЭХ-ын тооллогын комисст хурал хуралдуулахтай холбогдсон бусад үүргийг хариуцуулж болно.

4. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛДААН

4.1.ХУРАЛД ОРОЛЦОХ ХЭЛБЭР

Хувьцаа эзэмшигч нь ХЭХ-д дараах хэлбэрээр оролцож болно:

> Өөрийн биеэр;

> Өөр этгээдээр төлөөлүүлж;

> Урьдчилж тараасан саналын хуудсанд тусгасан хурлын шийдвэрийн төсөлд саналаа тусгаж илгээх замаар /энэ нь ХЭХ-ын бусад төрлийн хурлаас ялгагдах онцлог юм/.

Хувьцаа эзэмшигчийг төлөөлөн оролцох этгээд нь Иргэний хуульд заасны дагуу бичгээр олгосон итгэмжлэлийн дагуу төлөөлөх эрхээ хэрэгжүүлнэ. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь итгэмжлэлээр олгосон хүрээнд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд тухайн хурал болон хэлэлцэх асуудал нь өөрчлөгдөөгүй тохиолдолд хойшлогдсон хуралд оролцох эрх нь хүчинтэй хэвээр байна.

Саналын хуудсанд саналаа тусган илгээх замаар хуралд оролцсон хувьцаа эзэмшигчийг хуралд биеэр оролцсон бусад хувьцаа эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй адил статус бүхий оролцогч гэж үздэг. Энэ хэлбэрээр хуралд оролцож буй хувьцаа эзэмшигч нь өөрийн саналыг тусгасан хуудсаа түүнийг хүлээн авах сүүлийн өдрөөс өмнө хурлын зар болон мэдээлэлд заасан журмын дагуу хурал зарлагчид хүргүүлсэн байх ёстой.

Бүртгэлийн өдрөөс хойш хувьцаагаа бусдад шилжүүлсэн этгээд болон шинэ хувьцаа эзэмшигчид ХЭХ-д оролцох итгэмжлэл олгох, эсвэл шинэ

эзэмшигчийн өгсөн зааврын дагуу санал өгөх хэлбэрээр тухайн хуралд оролцож болно.

Компанийн хувьцааг хэд хэдэн этгээд дундаа хэсгээр өмчилж байгаа бол ХЭХ-д оролцож санал өгөх эрхийг дундаа хэсгээр өмчлөгчдийн харилцан тохиролцооноор хэн нэг нь, эсвэл тэдний итгэмжлэгдсэн төлөөлөгч хэрэгжүүлнэ.

4.2. ХУРАЛД ОРОЛЦОХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ БҮРТГЭХ

ХЭХ зарласан этгээд нь хурал хуралдуулах тухай шийдвэр гаргасны дараа ТУЗ-өөс тогтоосон “бүртгэлийн өдөр”-ийг хувьцаа эзэмшигчдийн бүртгэл хөтлөх эрх бүхий этгээдэд мэдэгдэн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрийн жагсаалтыг гаргуулан авч, тухайн хурлын “Тооллогын комисс”-т хүлээлгэн өгнө. Энэхүү жагсаалт нь хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүний эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо зэрэг мэдээллийг агуулсан байна.

Тооллогын комисс нь хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх этгээдээс ирүүлсэн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг хүлээн авч, түүнд байгаа мэдээллийг хурлын үед хувьцаа эзэмшигчдийн ирүүлсэн саналын хуудас дахь хувьцаа эзэмшигчийн мэдээлэлтэй тулгах замаар бүртгэж, дүнг тусгайлан протокол үйлдэж хурлын даргад хүргүүлнэ.

Санамж

Хуулийн этгээд хувьцаа худалдан авснаар хувьцаа эзэмшигч болох боловч уг хувьцаатай холбоотой эрхээ хэрэгжүүлэх нь зөвхөн тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд бүртгэгдсэн үеэс эхлэх тухай Компанийн тухай хуулийн 45 дугаар зүйлд заасан байдаг. Мөн энэхүү зүйлд хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг компани өөрөө хөтөлж байхаас гадна энэ ажиллагааг хариуцан хэрэгжүүлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж болохоор заасан. Өнөөдрийн байдлаар манай улсад хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх зөвшөөрөлтэй этгээд нь “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК болон кастодиан банкны зөвшөөрөл авсан арилжааны банкууд байна. Хувьцаат компани болон ихэнх төрийн өмчит компаниуд нь хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг “Үнэт цаасны

төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-тай гэрээ байгуулан хэрэгжүүлж байна. Иймд компаниуд тухайн хуралд оролцох ёстой хувьцаа эзэмшигчдийн нэрийн жагсаалтыг өөрийн компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэл хөтөлдөг этгээдээс авч хурлаа зохион байгуулах нь зүйтэй.

4.3 ХУРЛЫН ИРЦИЙГ ТОДОРХОЙЛОХ

ХЭХ нь хуралд оролцогчдын тоогоор ирцийг тодорхойлдоггүй. Үүгээрээ бусад хурлаас ялгаатай. Харин саналын эрхтэй хувьцаа эзэмшиж буй, тухайн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналын хуудаст заасан хувьцааны саналын эрхийн тоогоор хурлын ирцийг гаргадаг. “Тооллогын комисс” ирцийг тодорхойлж, энэ талаар тусгайлан тэмдэглэл үйлдэн хурал даргалагчид хүргүүлнэ. Даргалагч хурлын ирцийн талаарх тэмдэглэлийн дүнг үндэслэн ирцийг тогтоож, хурлын тэмдэглэлд тусгайлан тусгуулж, ирц болон хурлын хүчинтэй байх шаардлагыг хангасан эсэх талаар нийтэд мэдэгдэж, шаардлага хангасан бол хурлыг нээнэ. Компанийн дүрэмд илүү өндөр хувь тогтоогоогүй бол компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид ХЭХ-д оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно. ХЭХ-ын ирц дээрх хувьд хүрээгүй бол хурал хүчин төгөлдөр бус гэж үзэн хойшлуулж, дахин хуралдах өдрийг ТУЗ-өөс товлох бөгөөд энэхүү товлосон хурал нь хойшлогдсон хурал болох тул хэлэлцэх асуудлыг өөрчлөхийг хориглоно.

4.4.АСУУДАЛ ХЭЛЭЛЦЭХ ҮЙЛ ЯВЦ БА САНАЛЫН ХУУДСААР ИРҮҮЛСЭН САНАЛЫГ ТООЛОХ АЖИЛЛАГАА

Ихэнх тохиолдолд ХЭХ болохоос өмнө саналын хуудсаар гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчид саналаа тусгаад ирүүлдэг тул бусад хурлын адил хурал дээрээ асуудлаа хэлэлцэх нь харьцангуй бага байдгийг дээр дурдсан. Хурлын явцад хийгдэх гол ажил нь ирүүлсэн саналын хуудсанд хувьцаа эзэмшигчдийн тусгасан саналыг хурлаас гарах шийдвэр бүрээр тооцоолон гаргах ажиллагаа байдаг. Энэ ажлыг хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах үед хурал зарлагчаас томилсон “Тооллогын комисс” хэрэгжүүлдэг. Хувьцаа эзэмшигчдийн ирүүлсэн саналын тооцоог хувьцаа

эзэмшигч этгээдийн тоогоор бус тэдгээрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцааны тоогоор тооцдогийг анхаарах ёстой.

Ингэхдээ энгийн нэг ширхэг хувьцаа саналын нэг эрхтэй байх зарчмыг баримтална. Хувьцаа эзэмшигч бүр хурлаар шийдвэрлэх асуудал бүрээр санал өгөх эрхтэй боловч зарим хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцаа тухайн асуудлаар санал өгөх эрхгүй байх тохиолдол байдаг тул “Тооллогын комисс” тухайн хувьцаа эзэмшигчийн хувьцаа саналын эрхтэй эсэхийг нарийвчлан гаргах, хэрэв саналын эрхгүй бол уг хувьцаа эзэмшигчийг тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцоогүй гэж үзэж ирцээс хасаж тооцдог.

Харин давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдийн хувьд тэдгээрийн эзэмшиж буй хувьцаа нь ХЭХ-ын бүрэн эрхэд хамаарах нийтлэг асуудлаар саналын эрхгүй боловч тэдний эрхийг хязгаарласан, хөндсөн асуудлыг шийдвэрлэхэд зөвхөн давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналаар шийдэхээр Компанийн тухай хуульд зохицуулсан байдаг. Тухайлбал, Компанийн тухай хуулийн 35.6-д зааснаар “компанийн дүрэмд оруулж буй нэмэлт, өөрчлөлт болон компанийн дүрмийн шинэчилсэн найруулга нь давуу эрхийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарласан заалтыг оруулж байгаа, эсхүл компанийг өөрчлөн байгуулах явцад давуу эрхийн хувьцааг энгийн хувьцаа, бусад төрлийн үнэт цаас болон бусад хөрөнгөд хөрвүүлэх” асуудлыг хэлэлцэх тохиолдолд зөвхөн давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар шийдвэрлэхээр зохицуулсан.

4.5. ШИЙДВЭР ГАРГАХ АЖИЛЛАГАА

ХЭХ-ын шийдвэр нь хурлаас гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсаар ирүүлж зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэсэн хариулт бүхий хувьцааны нийт саналын тоогоор тодорхойлогдоно. Хурлын шийдвэр гаргах саналын тоо нь шийдвэрлэж буй асуудлаас хамаарч өөр өөр байж болно. Тухайлбал, ТУЗ-ийн гишүүнээр нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан хүнийг сонгохоор хурлын шийдвэр гардаг бол дараах асуудлыг хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн ирүүлсэн саналын дийлэнх олонхын саналаар шийдвэрлэхээр хуульд заасан байна.¹⁹ Үүнд:

¹⁹ Компанийн тухай хууль 63 дугаар зүйлийн 7 дахь хэсэг

> Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах.

> Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах.

> Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох.

> Компанийн хэлбэрийг өөрчлөх.

> Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох.

> Хувьцааг хуваах буюу нэгтгэх.


> Давуу эрхийн хувьцаа гаргах.

Эдгээрээс гадна давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналаар шийдвэрлэх асуудлыг зөвхөн хуралд оролцож байгаа давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор хурлын шийдвэр гарч байхаар Компанийн тухай хуульд зохицуулсан байна. ХЭХ-ын дарга нь санал хураалтын дүн болон хурлаас гарсан шийдвэрийг тухайн хурал дээр зарлан мэдээлэх үүрэгтэй.

4.6.ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ, ТҮҮНИЙГ ХӨТЛӨХ

ХЭХ дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор хурлын тэмдэглэлийг гаргаж, хурлын дарга гарын үсэг зурах бөгөөд уг тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцна. Хурлын тэмдэглэлд алдаа гарсан нь уг хурлын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

ХЭХ-ын тэмдэглэл нь Зураг 6-д тусгасан мэдээллийг агуулсан байна.



Зураг 6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд тусгах мэдээлэл

☒ **Санамж**

Компани болон хувьцаа эзэмшигч нь шаардлагатай гэж үзвэл ХЭХ-ын явцыг тодорхой техник хэрэгсэл ашиглан бичиж болно. Хэрвээ хувьцаа эзэмшигч бичлэг хийсэн бол түүний хувийг компани шаардан авч хадгална. Компани хувьцаа эзэмшигчдийн хурлын бичлэгийг хувиалан хадгалах нь бичлэгийн талаар дараа нь маргаан гаргахаас сэргийлж байгаа хэрэг юм.

5. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРААХ АЖИЛЛАГАА

5.1. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ БОЛОН ТҮҮНИЙ ШИЙДВЭРТЭЙ ХОЛБОГДОН ГАРЧ БОЛОХ ГОМДОЛ САНАЛ

ХЭХ, түүний шийдвэрийн талаар хуралд оролцоогүй, эсхүл оролцсон боловч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч дараах үндэслэлээр шүүхэд гомдол гаргах эрхтэй. Үүнд:

> Хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон журам, компанийн дүрэм зэрэгт заасны дагуу ХЭХ-ыг зарлаагүй бол

> ХЭХ хуралдах шийдвэр гарснаас хойш хуралдах өдөр, газрыг өөрчилсөн бол

> Хурал зарлагчаас хэлэлцэхээр товлоогүй асуудлыг хэлэлцсэн бол

Компанийн жижиг хувьцаа эзэмшигчид ХЭХ, түүнийг зарлан хуралдуулахтай холбоотой гомдол ихээр гаргадаг бөгөөд 2011 оны Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар энэхүү зохицуулалт шинээр бий болсон. Дээрх хуулийн зохицуулалтын хүрээнд энэ төрлийн гомдол, маргаан шүүх болон Санхүүгийн зохицуулах хороонд цөөнгүй үүсдэг болсон. Гомдол гаргах эрх бүхий этгээдэд тавигдах шаардлага нь хуралд оролцоогүй, эсхүл оролцсон ч тухайн асуудлаар эсрэг саналтай байсан этгээд байхыг шаарддаг онцлогтой. Тухайн гомдлоор ХЭХ-аар шийдвэрлэсэн тодорхой асуудлыг хэлэлцэхээс гадна, ихээхэн хэмжээний хөрөнгө, мөнгө, цаг хугацаа зарцуулж хуралдуулсан ХЭХ-ыг бүхэлд нь

хүчингүй болгох эрх зүйн боломжтой байдаг. Иймээс ХЭХ-ыг зохион байгуулахдаа хурал хуралдуулах шийдвэр гаргахаас эхлээд хурлын тэмдэглэл хөтөлж, шийдвэр гаргах, холбогдох баримт, материалыг эрх бүхий байгууллага болон нийтэд хүргэх хүртэл бүхий л ажиллагаанд хууль, журмыг чанд баримтлан ажиллах нь зүйтэй юм.

5.2.ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН БИЧИГ БАРИМТЫГ ЦЭГЦЛЭХ, ХУРЛЫН ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Хурал дууссаны дараа нийт хувьцаа эзэмшигчдэд хурлаас гарсан шийдвэрийг мэдээлж, шаардлагатай талуудад хурлын шийдвэрийг хүргүүлнэ. Хурал зохион байгуулсан тухай тайлан гаргах, гарсан тогтоол, шийдвэр, баримт бичгүүдийг нэгтгэн тухайн хурлын нэгдсэн тайланг гаргаж архивд шилжүүлэх зэрэг ажлууд хийгдэнэ.

Үүнээс гадна хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах талаар компанийн ТУЗ болон бусад талд үүрэг даалгавар өгөх, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнгийн талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх зэрэг ажлуудыг хийх нь зүйтэй. Эдгээр ажлыг компанийн ТУЗ-ийн даргын удирдлага доор ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан зохион байгуулж, үр дүнг нь тухай бүр хувьцаа эзэмшигчдэд мэдээлж байвал зохино.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийн биелэлтийг тусгайлан гаргаж, дараагийн хурлын материалын хамт хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх, мөн хурал дээр хувьцаа эзэмшигчдэд танилцуулж ажиллах нь компани болон хувьцаа эзэмшигчдийн хоорондын харилцааг сайжруулах, компанийн ил тод нээлттэй байдал, итгэл даасан байх зэрэгт чухал ач холбогдолтой байдаг.

ХАВСРАЛТУУД

1. Хавсралт-1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах санал гаргах хуудас
2. Хавсралт-2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар болон хурлын материал хүргүүлж байгаа тухай мэдээлэх хуудас
3. Хавсралт-3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудас
4. Хавсралт-4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал хүлээн авсан тухай мэдэгдэл
5. Хавсралт-5. Хувьцаа эзэмшигчийн итгэмжлэлийн загвар

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ
САНАЛ ГАРГАХ ХУУДАС

(ТУЗ-өөс бусад этгээд хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах санал гаргах
тохиолдолд энэ хуудсыг ашиглана.)

_____ компанийн нэр ТУЗ-ийн дарга _____ нэрийг бичих танаа

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах санал гаргагчийн нэр:
ТУЗ-ийн хараат бус гишүүн

..... овог нэр
..... овог нэр

Компанийн нийт гаргасан хувьцааны ... хувийг эзэмшигчид:

..... овог нэр регистрийн дугаар
..... овог нэр регистрийн дугаар
..... овог нэр регистрийн дугаар
..... овог нэр регистрийн дугаар

Компанийн тухай хуулийн 61.1.2-т заасны дагуу дараах асуудлыг хэлэлцүүлэх
зорилгоор компанийн ХЭХ-ыг хуралдуулах тухай саналыг үүгээр хүргүүлж байна.

Санал гаргаж буй шалтгаан

_____ шалтгааныг бичих

Хурлаар хэлэлцүүлэх асуудал:

_____ хэлэлцэх асуудлын нэр

Миний/Бидний энэхүү саналыг хүлээн авч хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохих
журмын дагуу хуралдуулж өгөхийг хүсье.

Санал гаргагч

_____ гарын үсэг / _____ / овог нэр
_____ гарын үсэг / _____ / овог нэр
_____ гарын үсэг / _____ / овог нэр

Санал гаргасан огноо:

_____ он _____ сар _____ өдөр

Хавсралт-2

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР БОЛОН ХУРЛЫН
МАТЕРИАЛ ХҮРГҮҮЛЖ БАЙГАА ТУХАЙ МЭДЭЭЛЭХ ХУУДАС

_____ компанийн нэр хувьцаа эзэмшигчдийн _____ ээлжит/ээлжит бус хурлын аль нь болохыг заах хурал
_____ оны _____ сарын _____ өдрийн _____ цагт _____ нд болно.

Хурал болох газрын хаяг: _____ /шаардлагатай гэж үзвэл байршлын зургийг
хавсралтаар үзүүлж болно/

Хурал зарлагч _____ ТУЗ, 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч, компанийн аудитор аль нь болохыг бичих

Хурал хуралдуулах тухай хурал зарлагчийн гаргасан шийдвэр - Үүнийг хавсралтаар
үзүүлэв.

Хэлэлцэх асуудал:

- a. _____ хэлэлцэх асуудлын нэрийг бичих
- b. _____ хэлэлцэх асуудлын нэрийг бичих
- c. _____ хэлэлцэх асуудлын нэрийг бичих

Хэлэлцэх асуудалтай холбоотой танилцуулах материалын жагсаалт:

- a.....
- b.....
- c..... гэх мэт /эдгээр материалыг хавсралтаар үзүүлнэ/

Хурлаас гарах шийдвэрийн төсөл:

- a.1 дүгээр асуудал
- b.2 дугаар асуудал
- c.3 дугаар асуудал гэх мэт /шийдвэрийн төслийг хавсралтаар тусгайлан үзүүлж
болно/

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрийн жагсаалт гаргах бүртгэлийн
өдөр

_____ он _____ сар _____ өдөр байна.

Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр:

_____ он _____ сар _____ өдөр байна.

Хурлаас гарах шийдвэрт таны санал өгөх “Саналын хуудас”-ыг хавсралтаар үзүүлсэн болно. Та хурлаас гарах шийдвэрийн төсөл болон түүнтэй холбоотой дээр дурдсан материалуудтай танилцаад хавсралтаар хүргүүлж буй “Саналын хуудас”-т тусгасан хурлаас гаргах шийдвэрийн төсөлд өөрийн саналыг тусган компани дээр таны санал, саналын хуудас авах сүүлийн өдөрт багтан ирсэн байхаар тооцоолон доор дурдсан буцах хаягаар илгээх, эсхүл энэхүү хурлыг хуралдуулахтай холбогдож бидэнтэй хамран ажиллаж байгаа _____ брокер, дилерийн _____компани эсхүл шуудангийн аль нэг нь болохыг заана -аар дамжуулан ирүүлэхийг хүсье.

Хэрэв “Саналын хуудас”-ыг шуудангаар илгээх бол таны саналыг хүлээн авах хаяг:

Хурал хуралдах болон дээр дурдсан асуудал, баримт бичигтэй холбоотой тодруулах, асуух, нэмж мэдээлэл авах шаардлага үүсвэл _____хаяг, _____ утсаар хандана уу.

Та энэхүү саналын хуудсанд саналаа тусган илгээснээр хувьцаа эзэмшигчдийн энэхүү хурлын хууль ёсны оролцогч болж, хурлын ирцийг бүрдүүлэхэд оролцохоос гадна таны ирүүлсэн санал хурлаас гарах шийдвэрт таны эзэмшиж буй хувьцааны тоогоор тооцогдон тусгагдах болно.

Та энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын хуудсаар саналаа илгээж оролцохоос гадна өөрийн биеэр ирж оролцох, мөн өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож болно.

Хурлын ирцийг таны овог, нэр, баталгаат гарын үсэг болон иргэний үнэмлэх дээрх регистрийн дугаар, таны эзэмшиж буй хувьцааны тоо зэргийг тусгасан “Саналын хуудасны мэдээллийг компани дээрх хувьцаа эзэмшигчдийн бүртгэл дэх таны мэдээлэлтэй тулган гаргах тул та “Саналын хуудас” дахь дээрх мэдээллийг үнэн зөв бөглөсөн байхаас гадна өөрийн биеэр оролцох тохиолдолд иргэний үнэмлэхтэйгээ ирэх, албан төлөөлөгчөө ирүүлэх тохиолдолд Иргэний хуульд заасны дагуу үйлдсэн итгэмжлэлийн хамт ирүүлэхийг зөвлөж байна. (Итгэмжлэлийн загварыг хавсралтаар үзүүлж болно.)

Та энэхүү хурлын мэдээллийг хүлээн авснаа хавсралтаар хүргүүлж байгаа “Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал хүлээн авсан тухай мэдэгдэл”-ийг бөглөн бидэнд доор дурдсан хаягаар, эсхүл бидэнтэй хамтран ажиллаж байгаа _____ брокер, дилерийн _____компани, эсхүл шуудангийн аль нэг нь болохыг заана дамжуулан ирүүлэхийг хүсье. Энэ нь таныг хувьцаа эзэмшигчийнхээ эрхийг хэрэгжүүлэх боломжийг хангах бидний үүрэг бага боловч хэрэгжиж байгаагийн баталгаа болохоос гадна энэ үүргийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж байгаа дээрх байгууллагатай хийх бидний тооцооны баримт болох юм.

_____компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлагч _____ туз, 10-
аас дээш хувийн хувьцаа эзэмшигч, компанийн аудитор аль нь болохыг бичих

-ийн албан ёсны төлөөлөгч _____ гарын үсэг / _____овогтой
_____ /

_____он _____сар _____өдөр.

“.....” -ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ
АСУУДЛААР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Регистрийн дугаар

Хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн дугаар

Эзэмшиж буй хувьцааны төрөл

тоо

Ээлжит хурал

20.. оны дүгээр сарын-ны өдрийн цагаасд болно.

Д/д	Хэлэлцэх асуудлын нэр	Хурлаас гаргах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
1.	Төлөөлөн удирдах зөвлөлийн 20... оны ажлын тайлан	 шийдвэрийн төслийг бичих				
2.	Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлт	- "-				

3.	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон хараат бус гишүүдийг сонгох					
	Ердийн гишүүн	1. _____ нэр дэвшигчийн нэр 2. _____ нэр дэвшигчийн нэр 3. _____ нэр дэвшигчийн нэр				
	Хараат бус	4. _____ нэр дэвшигчийн нэр 5. _____ нэр дэвшигчийн нэр 6. _____ нэр дэвшигчийн нэр 7. _____ нэр дэвшигчийн нэр 8. _____ нэр дэвшигчийн нэр 9. _____ нэр дэвшигчийн нэр				
4.	Төлөөлөн удирдах зөвлөлийн 20.. оны төсвийг батлах	_____ шийдвэрийн төслийг бичих				
5.	Ногдол ашиг хуваарилаагүй тухай танилцуулга	Шийдвэр гарахгүй				
6.						
7.						
8.						

Саналын хуудас хүлээн авах эцсийн өдөр дүгээр сарын болно.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон
Тооллогын комиссын дарга
гишүүд:
.....

Хүчингүйд тооцсон бол шалтгаан
.....
.....

Саналын хуудасны ар талд түүнийг бөглөх зааврыг бичих

- 1) Кумулятив аргаар санал хураан сонгох тохиолдолд ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч бүрд өгсөн саналын тооны нийлбэр нь тухайн хувьцаа эзэмшигчийн саналын эрхийн тооны нийт дүнгээс илүүгүй байх бөгөөд саналын эрхийн тооны нийт дүн нь тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа саналын эрх бүхий энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байх ба та энэхүү саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй хүмүүсийн аль нэгд нь, эсвэл сонгох хүсэлтэй хүмүүстээ хуваан саналаа өгч болохоос гадна нэр дэвшигчдээс татгалзах тохиолдолд татгалзсан баганад зохих тэмдэглэлийг хийж, таны өгөх санал гэсэн баганад өөрийн санал болгож буй хүний нэрийг нэмж оруулна уу.
- 2) ТУЗ-ийн гишүүнийг сонгохоос бусад тохиолдолд санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг нь [...] гэж тэмдэглэсэн байна. Энэхүү тэмдэглэлээс өөр тэмдэглэл хийвэл нь тухайн асуудлаарх таны санал хүчингүй болох тул та саналаа тэмдэглэхдээ үүнийг анхаарах нь зүйтэй.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР БОЛОН ХУРЛЫН МАТЕРИАЛ
ХҮЛЭЭН АВСАН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

_____компанийн хувьцаа эзэмшигч _____тоот регистрийн дугаартай _____
овогтой _____эсхүл түүний төлөөлөгч _____овогтой _____нь тус компанийн
_____оны _____сарын _____ний _____цагт _____нд болох хувьцаа
эзэмшигчдийн _____^{ээлжит/ээлжит бусын аль нь болохыг бичих} хурлын зарыг, хурлаар хэлэлцэх
асуудал болон хэлэлцэх асуудлын талаарх танилцуулгын хамт дор дурдсан
байдлаар хүлээн авснаа үүгээр баталгаажуулж байна. Үүнд:

1. Хэлэлцэх асуудал:

- a.
- b.
- c. гэх мэт

2. Хэлэлцэх асуудалтай холбогдсон танилцуулах материалын жагсаалт

- a.
- b.
- c. гэх мэт

Хурлын зар болон хурлын материал хүлээн авснаа баталсан

_____компанийн хувьцаа эзэмшигч _____
_____ гарын үсэг / _____ овог _____ нэр /
эсхүл _____
_____компанийн хувьцаа эзэмшигч _____регистрийн дугаартай _____
овогтой _____ийн албан ёсны төлөөлөгч _____
_____ гарын үсэг / _____ овог _____ нэр /
_____ он _____ сар _____ өдөр.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ИТГЭМЖЛЭЛ

Энэхүү итгэмжлэлийг гаргагч... улсын иргэн ... гэсэн регистрийн дугаартай ... овогтой ... би компанийн ... ширхэг саналын эрх бүхий хувьцааг эзэмшигч бөгөөд тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ... оны ... сарын ..нд болох хуралд намайг төлөөлөн ... улсын иргэн ... гэсэн регистрийн дугаартай ... овогтой ... ыг оролцуулж ХЭХ-аар хэлэлцэх дараах асуудалд дор дурдсан байдлаар санал өгүүлэхээр энэхүү итгэмжлэлийг гаргаж байна. Үүнд:

1. _____ хэлэлцэх асуудлын нэр _____ гарах шийдвэрийн нэр _____
зөвшөөрөх, татгалзах, түдгэлзэх эсэхээ бичих
2. _____ хэлэлцэх асуудлын нэр _____ гарах шийдвэрийн нэр _____
зөвшөөрөх, татгалзах, түдгэлзэх эсэхээ бичих
3. _____ хэлэлцэх асуудлын нэр _____ гарах шийдвэрийн нэр _____
зөвшөөрөх, татгалзах, түдгэлзэх эсэхээ бичих **ГЭХ МЭТ**

Итгэмжлэл гаргасан ... улсын иргэн ... гэсэн
регистрийн дугаартай ... овог овогтой ... нэр _____ гарын үсэг

Нотариатчийн тамга, тэмдэг, гарын үсэг, огноо
_____ овог овогтой _____ нэр _____
гарын үсэг
... оны ... сарын ... өдөр

ЛАВЛАХ МАТЕРИАЛ

1. Екатерина Ткаченко, Подготовка и проведение годового общего собрания акционеров. Практическое руководство для акционерных обществ, 1С-Паблишинг, 2004.
2. Г.Гудыма, Е. Костикова, И. Тыщук Общее собрание акционеров, Акционер, 2000.
3. Павел Настин, Общее собрание акционеров. Подготовка, созыв, проведение, Юстицинформ, 2008.
4. Путеводитель по корпоративным спорам. Общее собрание акционеров. Общее собрание участников ООО, Бизнес-журнал, 2012/2.
5. Александр Дедищев, Благополучие акционеров. Внешний и внутренний контроль над корпорацией, Дело, 2008.
6. Handbook for the Conduct of Shareholders' Meetings, Corporate Governance Committee, Section of Business Law, American Bar Association, 2000.
7. Handbook for the Conduct of Shareholders' Meetings 2nd Edition Edition by American Bar Association, 2010.
8. Corporate Shareholder Meetings: Issues Relating to Firms That Advise Institutional Investors on Proxy Voting - Scholar's Choice Edition, GAO-07-765: Published: Jun 29, 2007.
9. The Shareholders Meeting by Shin Ushijima, Mesatop Press (December 1, 2002)

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛТАЙ ХОЛБООТОЙ ӨРГӨН ХЭРЭГЛЭГДДЭГ
ЗАРИМ ҮГИЙН МОНГОЛ-ОРОС-АНГЛИ ТОЛЬ

Монгол	Орос	Англи
Бүртгэлийн өдөр	Дата закрытия регистра	Fixing Data /Registration day
Дийлэнх олонхын санал	Квалифицированное большинство голосов	Supermajority
Ердийн санал хураалт	Стандартное голосование	Standart Voting
Жижиг хувьцаа эзэмшигч	Миноритарные акционер	Minority Shareholder
Жилийн тайлан	Годовой отчет	Annual Report
Ирц	Кворум	Quorum
Итгэмжлэл	Доверенность	Proxy Card
Итгэмжлэлийг бичгээр гаргах	Письменные сообщения прокси	Written Proxy Statements
Кумулятив санал хураалт	Кумулятивное голосование	Cumulative Voting
Мэдэгдэл	Уведомление	Notice
Саналын хуудас	Бюллетень	Ballot
Саналын эрхтэй хувьцаа	Голосующие акции	Voting Shares
Санхүүгийн жил	Финансовый год	Fiscal Year
Тооллогын комисс	Счетная комиссия	Counting Commission
Төлөөлөл хэрэгжүүлэгч	Представительство	Proxy
Тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрх	Преимущественное право приобретение	Pre-Emptive Right
Хувьцааны тоо ба төрөл	Количество и тип акций	Number and Type of Shares
Хувьцаа эзэмшигчдийн бүртгэл	Регистр акционеров	Shareholder Register
Хувьцаа эзэмшигчдийн бүртгэл хөтлөгч	Регистратор	Registrar
Хувьцаа эзэмшигчдийн жагсаалт	Список акционеров	List of Shareholders

Хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хурал	Годовой общее собрание акционеров	Annual General Meeting of Shareholders
Хувьцаа эзэмшигчдээс хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаар санал гарах	Предложение акционеров	Shareholder Proposal
Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга	Председатель собрание акционеров	Chairperson Meeting of The Shareholders
Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогч	Участвующий акционеров	Participating Shareholder
Хувьцаа эзэмшигчдийн жилийн хурлын тэмдэглэл	Протокол годового собрания акционеров	Minutes of the Annual Meeting of Shareholders
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал	Внеочередное общее собрание акционеров	Extraordinary General Meeting of Shareholders
Хурал хуралдуулах санал гаргах	Зов собрание акционеров	Call of Meeting
Хурал хуралдуулахгүйгээр бичгээр саналаа гаргах	Письменное согласие на действие без заседания	Written Consent to Action Without Meeting
Хурлын зарыг хүлээн авсан тухай мэдэгдэл	Подтверждение получения уведомления о заседании	Acknowledgment of Receipt of Notice of Meeting
Энгийн олонхын санал	Простое большинство голосов	Simple Majority
Эчнээ санал хураалт	Заочное голосование	Voting in Absentia

ISBN 99978-803-2-3



9 789997 880321



“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.
Утас: 319658, 70140459
Вэб хаяг: www.munkhiin-useg.mn